

ЯПОН УЛСЫН ГЯЯ-НЫ САЙД БНМАУ-Д АЛБАН ЁСНЫ АЙЛЧЛАЛ АНХ ХИЙСЭН ТУХАЙ

Ц. Гүрбадам¹

I

Хүн төрөлхтөний түүхэнд нэрээ мөнхжүүлэн үлдээсэн монгол үндэстэн болон эртний түүхт Монгол улсын үүсэл хөгжил ба олон зууныг туулан өнгөрүүлсэн замнал нь үргэлж өөдрөг бадруун байсангүй. Хөгжиж дэвшиж, хүчирхэгжиж мандах, хүчинд автагдан сульдаж доройтох, дахиад сэргэж өндийх, бусад улстай дайтах, хэлцэж эвлэрэх, найрамдах, бас өөрсөд хоорондоо тэмцэлдэхийн аль алиныг нь үзсэн билээ.

Эдгээр огцом өөрчлөлт нугачаа нь монголчууд бидний өөрсдийн маань алдаа, онооноос гадна олон улсын байдал, хөрш гүрнүүдийн бодлого, хүчний харьцаа, тэдний геостратегийн ашиг сонирхлын солбицлын үр дагавар, нэг үгээр хэлбэл гадаад хүчин зүйлстэй холбоо хамааралтай байлаа. Тэдгээрийн дотроос Японы хүчин зүйл багагүй нөлөөтэй, бас ч чухал ач холбогдолтой байсан билээ.

Гэвч манай зарим түүхчид хэт улс төржиж нэг намын захиалгыг хангагч, түүний монопольжсон үзэл суртлыг сурталчлагч болсон тул түүхийн ээдрээтэй асуудлуудаас аль болохоор зайлсхийж тойрон гарах, арга буюу судалгаа хийхэд хүрвэл түүхэн үнэн, бодит баримтыг яг байгаагаар нь шинжлэн дүгнэхийн оронд өөртөө таалагдсаныг нь сугачин авах, өнгөц судлах, туйлшруулах хандлага голлож байсан учраас манай нийгэмд Японы тухай нэг талыг барьсан ерөөсгөл ойлголт, дургүйцэх үзэл буй болж хэвшсэн бөлгөө.

Тухайлбал, бага насандаа “Арлын годгор Япон Азийн ноён болох” гэсэн тухай шүлэг уншиж, Япон гэдэг орон нар мандах зүгт далай дээр байдаг хэмээн сонссон төдий мэдлэгтэй явсан миний бие сүүлдээ Япон улс тийм ч “годгорхон” жижиг улс биш, харин ч дэлхийн хамгийн баян орны нэг, цахим техник, өндөр технологийн амжилтаараа бусдыг манлайлж хурдан хөгжлөөрөө Японы гайхамшгийг дэлхийд үзүүлэн алдаршсан, олон улсын харилцаанд нэр хүнд, нөлөө бүхий хүчирхэг гүрэн мөн болохыг өөрийн биеэр үзэж өмнөх үеийн ойлголтоо орчин цагийн бодит байдалтай харьцуулан эрэгцүүлэл хийж яваагаа нуух юун.

Монгол-Японы харилцааны түүхийг үнэн мөнөөр нь нягтлан бичиж авахыг нь авч, гээхийг нь гэж, туйлшруулсан буруу ташаа ойлголтуудыг залруулж хожмын үйлсдээ сургамж авах, өмнөх үеэс уламжлагдаж ирсэн сэтгэл санааны саадыг арилгах, түншлэлийн хэтийн төлвийг тодорхойлж бааз суурийг нь бэхжүүлэхэд ямар нэг хэмжээгээр оролцож явсныхаа нэгэн учралыг дурсамж болгон өгүүлье.

Би 1984-1990 онуудад ЗХУ-д Элчин сайдаар ажиллаж байхдаа Ази тивийн хүчирхэг орон Японы Элчин сайдтай нэг бус удаа уулзан ярилцаж байсан бөгөөд тэрбээр 1989 оны 5 дугаар сарын эхээр надтай уулзахдаа: “Манай улсын Гадаад явдлын яамны сайд ноён Сосүкэ

¹ МУИС, ОУХС-ийн багш, доктор /Sc.D/, профессор. ЗХУ-д 1984-1990 онуудад Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайдаар ажиллаж байсан. Хүндэт дипломатч.

Үнө тун удахгүй ЗСБНХУ-д Гадаад явдлын яамны сайд, ноён Э.А.Шевардназе-гийн урилгаар албан ёсны айлчлал хийх гэж байна. Дараа нь танай БНМАУ-д бас айлчлах болно” гэж мэдэгдэж билээ.

Иймээс сайд С.Үнотой уулзаж Улаанбаатар руу үдэж мордуулах ажил гарах нь тодорхой боллоо. Тэр үед би Япон улсын тухай зориуд сонирхож яваагүй учраас юмыг яаж мэдэхэв, хоёр орны түүхийн талаар ямар нэг асуудал яригдвал тодорхой хариулах зорилгоор хамгийн ерөнхий хэдэн үйл явдлыг япон судлаачдын бичсэн зүйлээс уншиж “биеэ цэнэглэж” авлаа.² Ингээд миний юун түрүүнд онцолж авсан зүйл гэвэл:

Олон зуун жилийн өмнө XIII зуунд Хубилай хаан анх удаа 1274 онд, дараа нь 1275, 1279 онуудад далайн флотын асар их хүчээр Япон руу дахин довтолсон боловч “камиказе” гэж нэрлэгдсэн хар салхи болсноор ямар ч үр дүнд хүрээгүй ажээ.

Өнгөрсөн XX зууны эхээр Богд хаант Монгол улс дипломат харилцаа тогтоох асуудлаар Японы эзэн хаанд 1913, 1914 онуудад албан бичиг илгээж байсан боловч түүнийг нь ЗХУ-ын зүгээс дэмжээгүй тул тэр нь түүхийн архивт цаас болон хоцорчээ.

Манай улс Японтой дипломат харилцаагүй тул ЗХУ-аар дамжуулж ашиг сонирхлоо илэрхийлдэг байжээ. Иймээс Монголын удирдагчид Японы талаар ямар бодлого явуулахыг генералисмуc И.Сталин, ЗХУ-ын гадаад харилцаа болон аюулаас хамгаалах албаныхан маш соргоогоор ажиглаж, монголчууд япончуудтай нөхөрлөхийг эрмэлзэх буй хэмээн хардан хянаж, элдэв хориг тээг тавьж байсан нь нууц бишээ. Гэвч хоёр талаасаа холбоо тогтоож шууд ярилцах оролдлогыг нэг бус удаа хийсээр байжээ. Жишээлбэл, Москвад сууж байсан Монгол, Японы дипломатчид 1926-1928 онуудад хэд хэдэн удаа уулзаж санал солилцож байсан ба Японы консул Монголд ирэх визийг Ерөнхий сайд Амар өгсөн боловч Зөвлөлтийнхэн эсэргүүцсэний улмаас виз өгөхөө түр хойшлуулсан ажээ.

БНМАУ-ын удирдагчид Японтой харилцахдаа туйлын болгоомжтой хандаж асуудлыг хурцатгалгүй гэрээ хэлэлцээний аргаар шийдвэрлэхийг чармайж Монгол улсаа Японоор хүлээн зөвшөөрүүлэхийг зорьж байсан хэдий ч зарим нь хэлмэгдэж амиа алдаж байсан.

БНМАУ-ын талаарх Японы идэвхтэй бодлого үндсэндээ гурван үйл явдал дээр төвлөрсөн бөгөөд нэгд, 1935-1937 онд БНМАУ-Манжго-гийн хоорондын шууд яриа хэлэлцээ, хоёрт, БНМАУ-ын нутагт Халхын гол орчим болсон байлдаан, түүнтэй холбогдсон Зөвлөлт-Японы хооронд үүссэн цэрэг, дипломатын зөрчил, гуравт, Зөвлөлт-Японы төвийг сахих 1941 оны гэрээ, уул гэрээний дагуу БНМАУ болон Манжго-гийн тухай тусгай тунхаглал гаргасан нь чухамдаа БНМАУ гэдэг эрх зүйн субъект байгааг Японоор анх удаа зөвшөөрүүлэхийн хамт Манжго-гийн оршин тогтнож байгааг ч ЗХУ бас зөвшөөрсөн хэрэг байлаа.

Үүний зэрэгцээ 1939, 1945 онуудын үйл явдлуудын тухай яригдвал “Танакагийн меморандум” гэсэн баримт бичигт “МанМо” нь Японы оршин тогтнох орон зайн тэргүүн шугам”, “Хятадыг эзлэн авахын тул юун түрүүнд Манжуур, Монголыг эзлэх хэрэгтэй. Дэлхийг эзлэх гэвэл юуны өмнө Хятадыг эзлэн авах хэрэгтэй” гэсэн зорилготой байсан гэдгийг санаандаа сэргээв.

Халх голын байлдаан /хилийн мөргөлдөөн ч гэдэг/, 1945 оны чөлөөлөх дайны үеийг сурагч байх үеэсээ өөрийн биеэр мэдэрч явсан тул ямар нэгэн асуулт сэтгүүлч, сурвалжлагчдын зүгээс гарвал нэг их түүртэхгүйгээр хариулах байх гэж өөрийгөө тайтгаруулав.

Япон улсын ГЯЯ-ны сайдтай уулзаж улмаар түүнийг эх орондоо зочноор явуулна гэж ЗХУ-д суугаа Элчин сайд би хэзээ ч бодож байгаагүй, энэ мэт санаанд ороогүй, гэнэтийн тохиолдол үе үе гардгийг элчин сайдууд бүгд мэднэ.

² Энэ дашрамд өгүүлэхэд миний аавыг Гэндэн, Дэмидийн нууц байгууллагын гишүүн, Японы тагнуул гэж ямар ч ор үндэсгүйгээр хэлмэгдүүлэн 1938 онд 44 настайд нь цаазалсан юм. Би тэр үед 4 настай байсан гэдэг. Олон жил өнгөрсний дараа ээжээсээ: “Манай аав үнэхээр Японы тагнуул байсан юм биш биздээ” гэж асуухад минь “Аав чинь Япон улс гэдгийг мэдэх байтугай Биндэр сумынхаа төвөөс цааш гарч үзээгүй хүн. Яахлаараа тэр улсын тагнуул болдог байнаа, мэдэхгүй юмаа хөвүүн минь” гэж ээж хэлээд эрхээ эргүүлж билээ.

II

Япон улсын Элчин сайдын мэдэгдсэний дагуу цаашдын үйл явдал өрнөж эхлэв. Япон улсын ГЯЯ-ны сайд С.Үно ЗХУ-д хийсэн айлчлалаа дуусгаад 1989 оны 5 дугаар сарын 5-нд манай улсад айлчлах болсон тул түүнтэй нүүр учран танилцаж Москвагаас эх орондоо үдэж мордуулах хариуцлагатай бөгөөд аз завшаантай нэгэн үйл явдал миний амьдралд тохиолдсон юм. Ноён сайдыг үдэж мордуулахаар ЗХУ-ын ГЯЯ-ны сайд Э.А.Шевардназе нисэх онгоцны тусгай буудал “Внуково-2”-д хүрэлцэн ирэв. Японы сайд ч хүрэлцэн ирлээ. Би, манай ЭСЯ-ны ёслолын асуудал хариуцсан дипломатч Л.Наянжин³, ГЯЯ-наас Москвад ирсэн тусгай төлөөлөгч Нархажид нарын хамт 18 цагт онгоцны буудалд эртлэн ирээд хүлээж байлаа.

Эрхэмсэг сайдуудыг тосон авч уулзаад тусгай өрөөнд орж кофе уух зуур ярилцав. Би сайд С.Үнод хандаж “Япон улсын ГЯЯ-ны сайд Таны манай улсад хийх гэж байгаа анхны албан ёсны айлчлалыг БНМАУ-ын Засгийн газар маш өндрөөр үнэлж их ач холбогдол өгч байна. Таны айлчлал манай хоёр улс, ард түмний харилцааны түүхэнд шинэ хуудас нээж байгаад Элчин сайд миний бие туйлаас баярлаж байна” гэв.

Сайд С.Үно хариу талархал илэрхийлээд Монголд одоо цаг агаар ямар байгаа бол гэж асуухад нь нийслэл Улаанбаатар хотод +10 С орчим дулаан байгаа, гэвч манай цаг уурын байдал тун ч тогтворгүй, яаж ч хувирч өөрчлөгдөж мэднэ гэж хэлэхэд минь Японы сайдын орчуулагч түүнд орчуулж өгөв.

Ингэж хэлээд дуустал сайд Э.А.Шевардназе⁴ “Но, монгольский народ не капризный, очень добродушный народ”⁵ гэж хэлэхэд нь бид гурав их баярлаж билээ. Дараа нь сайд С.Үно Монголын талаас оролцож буй бид гуравт хандаж “Та нарыг хараад би манай япончууд байна гэж бодлоо” хэмээн хэлсэн нь сэтгэлд их таалагдсан бөгөөд цаанаа гүн утга агуулгатай үг байсан нь хоёр орны дараах жилүүдийн хамтын ажиллагааны явцад улам тодорсон юм. Түр зуур сууж ийнхүү ярилцсаны дараа сайд С.Үно бидэнд баяр талархал илэрхийлээд онгоцондоо суухад онгоц нь 18 цаг 35 минутад агаарт хөөрч Монгол улсыг чиглэн ниссээр бараа тасрав.

Энд нэг зүйлийг тодруулж хэлэхэд тэрхүү хөлөглөн суусан онгоц нь “МИАТ” компанийн ТУ-134Б маркийн онгоц байсан бөгөөд экипаж, үйлчлэгчид нь цөм манайхан байлаа. Энэ нь гайхал төрүүлэхээсээ илүү баярлах сэтгэл төрүүлэв. Япон улсын ГЯЯ-ны сайд өөрийнхөө онгоцоор Монголд ирэхгүй “МИАТ” компанийн онгоцыг хөлслөн авсан нь дипломат бодлогын нэгэн тод илрэл байсан болой.

Манай хоёр улс 1972 онд дипломат харилцаа тогтоосноос хойш 17 жилийн дараа Японы ГЯЯ-ны сайдын хийсэн энэхүү албан ёсны айлчлал нь өндөр хэмжээний айлчлалын анхных байсан төдийгүй улмаар Монгол, Японы цаашдын харилцааг идэвхжүүлж иж бүрэн түншлэлийн үндсийг тавихад чухал ач холбогдолтой учраас Монгол улс түүнийг ёслол төгөлдөр хүндэтгэлтэйгээр хүлээж авсан билээ.

Японы Эзэн хааны шагналт, академич Т. Намжим талийгаач Сосүкэ Үногийн тухай дурсаж бичихдээ “С.Үно бол Шига мужийн Морияма хотын уугуул хүн бөгөөд амьдрал тэмцэл, ажил үйлсийн урт замыг туулсан, дайн дажинтай цаг үед цэрэг цуухайд дайчлагдан явж, Сибирь нутагт хоёр жил олзонд байсан, зовлон бэрхшээлийг амссан, эх орон, нутаг усныхандаа нэр цуутай хүн байжээ. ...С.Үно гуайн манай улсад хийсэн айлчлалын үеэр нэг өдөр Гадаад явдлын яаманд барьсан үдийн зоог дээр манай алдарт дуучин, Ардын жүжигчин Норовбанзад

³ Дашрамд өгүүлэхэд, тэр үед гадаадын 52 орны Элчин сайдууд Москвагаас БНМАУ-д суугаа Элчин сайдын албыг хавсран гүйцэтгэж байсан тул манай ЭСЯ ёслолын асуудал хариуцсан хоёр ажилтантай байсан юм.

⁴ Э.А.Шевардназе гүрж үндэстэн бөгөөд агуу их ЗХУ-ын ГЯЯ-ны сайдын хувьд нэн ухаалаг гадаад бодлого явуулж олон улсын хэмжээнд ихээхэн нэр хүндтэй болсноос гадна өөрчлөн байгуулалтын бодлогын онол, үзэл санааны удирдагчдын нэг байлаа. Тэрбээр 1986 онд Монгол, Зөвлөлтийн харилцааны 65 жилийн түүхэнд анх удаа манай улсад айлчилсан ЗХУ-ын ГЯЯ-ны сайд билээ. Э.А.Шевардназе 1 дүгээр сарын 24-нд мэдэгдэхдээ: БНМАУ, АНУ-тай дипломат харилцаа тогтоох явдал бидний сонирхолд нийцнэ гэж үзэж байна гэсэн бөгөөд 1921 оноос АНУ-тай дипломат харилцаа тогтоох талаар хийсэн оролдлого 1987 оны 1 дүгээр сарын 27-нд биеллээ олсон билээ.

⁵ Монголын ард түмэн ороо бусгаа зангүй, сайхан сэтгэлтэй ард түмэн юм шүү.

тэргүүтэй урлагийн хэсэг авьястнууд ая дуугаа өргөсөн билээ. Тэгээд тэд нар бидний тоглолт дууслаа гэдгээ мэдэгдээд явангуут Үно гуай одоо уран сайхны тоглолт үргэлжилнэ гэж хэлээд ... микрофоны өмнө очиж халааснаасаа аман хуур гаргэж япон ардын нэг дуу, орос үндэстний “Катюша” хэмээх дууг хөгжимдөөд одоо би монгол ардын дуу тоглоно гэж хэлээд “Хүмүүн төрөлхтөн”-ий аяыг маш сайхан тоглож билээ. Түүний тоглосон аман хуур нь том аккордион хөгжим шиг гойд сайхан дуутай байсан нь манайхны гайхлыг төрүүлж байсансан. Үно гуай Японы аман хуурчдын уралдаанд 2-р байр эзэлсэн, бас шүлэг бичдэг, ер нь их авяастай хүн хэмээн дараа нь хүмүүс ярилцаж байж билээ” гэсэн байдаг.

Японы улс төр, нийгмийн том зүтгэлтэн, нэртэй дипломатч тэр сайд Монгол улсад айлчлал хийснээс хойш эдүгээ 20 жил болж байгаа бөгөөд харамсалтай нь тэрбээр 1998 оны 5 дугаар сард таалал төгсжээ.

III

Монгол, Япон хоёр орны түүх дайн дажингүй, энх амгалан байдлаар хөгжиж ирээгүй нь нэн харамсалтай. Энэ онд Халх голын байлдааны 70 жилийн ойг тэмдэглэх, Чойбалсан хотыг баатар хот болгох тухай яригдаж байна. Миний бодлоор бол аливаа нэг түүхэн үйл явдал болдгоороо болоод өнгөрдөг, түүнийг байнга дурсаж ойг нь тогтмол тэмдэглээд байх шаардлагагүй гэж үздэг тал ч бий, бас тэмдэглээд байх шаардлагатай ч байдаг. Үүний аль нэг хувилбарыг улс төрчид, цэргийнхэн, дипломатчид тал бүрээс нь шүүн тунгааж нэгдсэн нэг дүгнэлт хийгээд сонгож авбал сөрөг үр дагавар гарахгүй бизээ. Тэгэхдээ ямар учраас мартах, эсхүл юуны тул үргэлж дурсаж байхын учир шалтгаан нь олон нийтэд ойлгомжтой, үнэмшилтэй байх нь чухал.

Манай улсын хөгжлийн өнөөгийн байдал болон ирээдүйд Японы хүчин зүйл чухал ач холбогдолтой гэдэг нь бүхэнд тодорхой болоод байна. Иймээс хойшоо биш, урагшаа харж, өнгөрсөн цагийн муу зүйлийг умартаж, ирээдүйг эрхэмлэсэн хүмүүнлэг сэтгэлийн үүднээс хандаж япончуудыг байнга зэмлэн буруушаасаар байх бус, цэрэг, зэвсгийн хүч хэрэглэн Монгол улсад халдан дайтаж байсан нүглийг нь уучлан улс орныхоо хөгжил, дэвшилд Японы хүчин зүйлийн эерэг нөлөөг ухаалгаар ашиглах талаас нь илүү анхаарч байх нь зүйтэй бус уу.